



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
БАЯНЛИГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2022 оны 05 сарын 16 өдөр

Дугаар А/52

Хатан суудал

**Хэрэглэгчийн эрхийг хамгаалах
орон тооны бус салбар зөвлөл байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын Хэрэглэгчийн эрхийг хамгаалах орон тооны бус салбар зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Зөвлөлийн дарга: Засаг даргын орлогч

Нарийн бичгийн дарга: Хүнс, жижиг дунд үйлдвэр, хоршооны асуудал
хариуцсан мэргэжилтэн

Гишүүд:

Хэсгийн төлөөлөгч

Мал эмнэлгийн тасгийн дарга

Нийгмийн бодлогын мэргэжилтэн

Хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтэн

Их халбагант 1 дүгээр багийн Засаг дарга

Баян-Аараг 2 дугаар багийн Засаг дарга

Бага баян 3 дугаар багийн Засаг дарга


Их баян 4 дүгээр багийн Засаг дарга

Хатансуудал 5 дугаар багийн Засаг дарга

2.Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж, зөвлөлийн үйл ажиллагааг удирдлага, арга зүйгээр ханган ажлын төлөвлөгөө гаргаж хагас бүтэн жилээр биелэлтийг тооцон ажиллахыг Зөвлөлийн дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Г.Мөнхсүх)-д даалгасугай.

ДАРГА  О.МӨНХБАТ



642201025